



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 2/194

Бат-Өлзий сум


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5.9, 4.5.12 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 1-6 багийн малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд 9,000,000 (Есөн сая) төгрөг, суманд тэжээлийн нөөц бүрдүүлэх зардалд 8,000,000 (Найман сая) төгрөг, нийт 17,000,000 (Арван долоон сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 17,000,000 (Арван долоон сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН